



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/413

Улаанбаатар хот

「 Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын эргэлтийн бус хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны оны 09 дугаар сарын 29-ний өдрийн 09 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 39,600,000.00 (гучин есөн сая зургаан зуун мянга) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасан байгууллагуудын баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (Г.Ганбаяр)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг хавсралтад заасан байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В.Оюумаа* В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн Д/У.Д. дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт
 Байгууллага: Нийслэлийн цагдаагийн удирдах газар

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалта д орсон он	Хэмжээ	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл /2025 оны 10 сарын 31-ны өдрийн байдлаар/	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	Суурин Компьютер (dell optiplex tower)	2025.09.03	ш	2	1,980,000	3,960,000.00	132,000.00	3,828,000.00	Баянгол дүүргийн цагдаагийн газар	Шилжүүлэн авах байгууллага
2	Суурин Компьютер (dell optiplex tower)	2025.09.03	ш	2	1,980,000	3,960,000.00	132,000.00	3,828,000.00	Сүхбаатар дүүргийн цагдаагийн газар	Шилжүүлэн авах байгууллага
3	Суурин Компьютер (dell optiplex tower)	2025.09.03	ш	2	1,980,000	3,960,000.00	132,000.00	3,828,000.00	Хан-Уул дүүргийн цагдаагийн газар	Шилжүүлэн авах байгууллага
4	Суурин Компьютер (dell optiplex tower)	2025.09.03	ш	2	1,980,000	3,960,000.00	132,000.00	3,828,000.00	Чингэлтэй дүүргийн цагдаагийн газар	Шилжүүлэн авах байгууллага
5	Суурин Компьютер (dell optiplex tower)	2025.09.03	ш	2	1,980,000	3,960,000.00	132,000.00	3,828,000.00	Нийслэлийн цагдаагийн удирдах газар	Налайх дүүргийн цагдаагийн хэлтэс

6	Суурин Компьютер (dell optiplex tower)	2025.09.03	ш	4	1,980,000	7,920,000.00	264,000.00	7,656,000.00	Баянзүрх дүүргийн цагдаагийн газар
7	Суурин Компьютер (dell optiplex tower)	2025.09.03	ш	4	1,980,000	7,920,000.00	264,000.00	7,656,000.00	Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газар
8	Суурин Компьютер (dell optiplex tower)	2025.09.03	ш	1	1,980,000	1,980,000.00	66,000.00	1,914,000.00	Багануур дүүргийн цагдаагийн хэлтэс
9	Суурин Компьютер (dell optiplex tower)	2025.09.03	ш	1	1,980,000	1,980,000.00	66,000.00	1,914,000.00	Багахангай дүүргийн цагдаагийн хэлтэс
	НИЙТ ДҮН			20	17,820,000	39,600,000	1,320,000	38,280,000	